



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2024/193/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Б.Ундарьяа

Утас: 70376994 Цахим хаяг: [undariya11@gmail.com](mailto:undariya11@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	16
3.5.3 Нэмэлт төсөв: .....	17
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2. Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.5.1 Завсрын аудитын талаар .....	20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	21
5.1 Төлбөрийн акт .....	21
5.1 Зөвлөмж .....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ХУШААТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Э.АРИУНАА ТАНАА

2024.02.23 № СМ-2024/193/НН-СМ-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 40,518.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13,674.4 мянган төгрөгийн ном, технологийн кабинетийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт,

018020274

санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он <i>/төгрөгөөр/</i>
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>81,599,491.41</b>	<b>136,086,009.17</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>71,337,788.14</b>	<b>109,310,624.23</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>71,337,788.14</b>	<b>109,310,624.23</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>71,337,788.14</b>	<b>109,310,624.23</b>
31211	Төрийн сангийн харилцах	71,337,788.14	109,310,624.23
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>2,719,805.20</b>	<b>0.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>2,719,805.20</b>	<b>0.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	2,719,805.20	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>7,541,898.07</b>	<b>26,775,384.94</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>0.00</b>	<b>2,793,304.94</b>
35110	Тусгай зориулалттай материал	0.00	2,793,304.94
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,500.00	0.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>7,540,398.07</b>	<b>23,982,080.00</b>
35410	Бичиг хэргийн материал	2,184,000.00	408,600.00
35420	Аж ахуйн материал	113,500.00	0.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	949,900.00
35460	Хүнсний материал	5,498.07	0.00
35470	Бусад хангамжийн материал	5,237,400.00	22,623,580.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,351,252,526.84</b>	<b>1,353,836,841.74</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,351,252,526.84</b>	<b>1,353,836,841.74</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,321,152,526.84</b>	<b>1,323,736,841.74</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,315,727,094.28	1,315,727,094.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(125,236,360.80)	(175,871,529.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,499.68)	(14,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	93,691,495.40	160,518,215.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,488,755.94)	(36,710,532.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,443,755.93	61,523,755.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,601,799.79)	(26,077,590.85)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,415,800.00	0.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(424,739.88)	0.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,556,300.00	15,972,100.00

39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,455,629.88)	(4,920,612.22)
39217	Ном	11,525,367.20	13,575,941.30
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>30,100,000.00</b>	<b>30,100,000.00</b>
39301	Программ хангамж	225,000.00	225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(225,000.00)	(225,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,100,000.00	30,100,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,432,852,018.25</b>	<b>1,489,922,850.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>34,507,760.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>34,507,760.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>34,507,760.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	34,507,760.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,432,852,018.25</b>	<b>1,455,415,090.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,432,852,018.25</b>	<b>1,455,415,090.91</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	252,501,089.66	252,501,089.66
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	252,501,089.66	252,501,089.66
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>490,110,983.52</b>	<b>512,674,056.18</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(941,329,608.53)	490,110,983.52
51220	Тайлант үеийн үр дүн	1,431,440,592.05	22,563,072.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	690,239,945.07	690,239,945.07
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,432,852,018.25</b>	<b>1,489,922,850.91</b>

## 2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,312,992,580.37</b>	<b>1,126,407,241.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,373,365,166.54</b>	<b>71,974,197.04</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,373,365,166.54</b>	<b>71,974,197.04</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,529,300.00</b>	<b>2,574,400.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,574,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,529,300.00	0.00
120009	Бусад орлого	0.00	1,167,018.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,364,494,589.47	54,193,294.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,341,277.07	14,039,484.94
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>939,627,413.83</b>	<b>1,054,433,044.84</b>

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>781,008,100.00</b>	<b>918,051,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	781,008,100.00	918,051,100.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>158,619,313.83</b>	<b>136,381,944.84</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158,619,313.83	136,381,944.84
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>881,551,988.32</b>	<b>1,103,844,169.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>881,551,988.32</b>	<b>1,103,844,169.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>833,555,970.32</b>	<b>1,071,977,619.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>542,753,058.98</b>	<b>671,437,587.20</b>
210101	Үндсэн цалин	400,242,011.47	478,475,755.13
210102	Нэмэгдэл	109,922,723.51	169,945,352.91
210104	Урамшуулал	12,985,915.00	23,016,479.16
210105	Гэрээт ажлын хөлс	19,602,409.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,640,059.88</b>	<b>84,602,109.71</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,400,339.46	58,407,427.78
210202	Тэтгэмжийн даатгал	5,458,860.01	6,713,632.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,350,288.05	5,359,574.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,034,696.30	1,283,862.14
210205	Эрүүл мэндийн даатгал	10,395,876.06	12,837,612.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>125,460,038.83</b>	<b>162,997,104.84</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,593,638.83	9,615,544.84
210302	Түлш, халаалт	115,094,900.00	149,610,060.00
210303	Цэвэр, бохир ус	3,771,500.00	3,771,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,037,850.00</b>	<b>31,480,983.07</b>
210502	Хоол, хүнс	28,037,850.00	31,480,983.07
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,267,500.00</b>	<b>7,892,600.00</b>
210604	Урсгал засвар	11,267,500.00	7,892,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,880,200.00</b>	<b>6,451,180.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,324,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,880,200.00	4,126,780.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>54,517,262.63</b>	<b>107,116,054.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,287,600.00	24,670,175.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,251,600.00	7,072,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,978,062.63	75,372,979.20

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,996,018.00	31,866,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,996,018.00	31,866,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,600,700.00	31,866,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,395,318.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,431,440,592.05	22,563,072.66
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,431,440,592.05	22,563,072.66

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	942,156,713.83	1,058,174,462.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,529,300.00	3,741,418.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,529,300.00	3,741,418.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,529,300.00	2,574,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	2,574,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,529,300.00	0.00
120009	Бусад орлого	0.00	1,167,018.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	939,627,413.83	1,054,433,044.84
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	781,008,100.00	918,051,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	781,008,100.00	918,051,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	158,619,313.83	136,381,944.84
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	158,619,313.83	136,381,944.84
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	848,857,925.69	996,437,626.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	848,857,925.69	996,437,626.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	800,861,907.69	964,572,576.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	542,753,058.98	671,437,587.20
210101	Үндсэн цалин	400,242,011.47	478,475,755.13
210102	Нэмэгдэл	109,922,723.51	169,945,352.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	12,985,915.00	23,016,479.16
210105	Гэрээт ажлын хөлс	19,602,409.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,640,059.88	84,602,109.71
210201	Тэтгэврийн даатгал	46,400,339.46	58,407,427.78

210202	Тэтгэмжийн даатгал	5,458,860.01	6,713,632.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,350,288.05	5,359,574.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,034,696.30	1,283,862.14
210205	Эрүүл мэндийн даатгал	10,395,876.06	12,837,612.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>125,460,038.83</b>	<b>128,489,344.84</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,593,638.83	9,615,544.84
210302	Түлш, халаалт	115,094,900.00	115,102,300.00
210303	Цэвэр, бохир ус	3,771,500.00	3,771,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,037,850.00</b>	<b>31,475,485.00</b>
210502	Хоол, хүнс	28,037,850.00	31,475,485.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,267,500.00</b>	<b>7,892,600.00</b>
210604	Урсгал засвар	11,267,500.00	7,892,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,880,200.00</b>	<b>7,921,180.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,324,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,880,200.00	5,596,780.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,823,200.00</b>	<b>32,754,270.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,287,600.00	24,357,770.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,535,600.00	8,396,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,996,018.00</b>	<b>31,865,050.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>47,996,018.00</b>	<b>31,865,050.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,600,700.00	31,865,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,395,318.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>93,298,788.14</b>	<b>61,736,836.09</b>
<b>IV</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>21,961,000.00</b>	<b>23,764,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,961,000.00</b>	<b>23,764,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>21,961,000.00</b>	<b>23,764,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,961,000.00	23,764,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(21,961,000.00)</b>	<b>(23,764,000.00)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>71,337,788.14</b>	<b>37,972,836.09</b>

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	71,337,788.14
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,337,788.14	109,310,624.23

## 2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	252,501,089.66	690,239,945.07	(941,329,608.53)	1,411,426.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,501,089.66	690,239,945.07	(941,329,608.5)	1,411,426.20
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,431,440,592.05	1,431,440,592.05
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,501,089.66	690,239,945.07	490,110,983.52	1,432,852,018.25
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	252,501,089.66	690,239,945.07	490,110,983.52	1,432,852,018.25
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	252,501,089.66	690,239,945.07	490,110,983.52	1,432,852,018.25
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	22,563,072.66	22,563,072.66
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	252,501,089.66	690,239,945.07	512,674,056.18	1,455,415,090.91

## 2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,129,512,232.98	1,020,201,626.75	109,310,606.23	90.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,129,512,232.98	1,020,201,626.75	109,310,606.23	90.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ	1,129,512,232.98	988,336,576.75	141,175,656.23	87.5

	<b>ЗАРДАЛ</b>				
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>754,179,900.00</b>	<b>671,437,587.20</b>	<b>82,742,312.80</b>	89.0
210101	Үндсэн цалин	519,210,000.00	478,475,755.13	<b>40,734,244.87</b>	92.2
210102	Нэмэгдэл	207,859,200.00	169,945,352.91	<b>37,913,847.09</b>	81.8
210104	Урамшуулал	26,825,200.00	23,016,479.16	<b>3,808,720.84</b>	85.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>94,272,400.00</b>	<b>84,602,109.71</b>	<b>9,670,290.29</b>	89.7
210201	Тэтгэврийн даатгал	64,105,300.00	58,407,427.78	<b>5,697,872.22</b>	91.1
210202	Тэтгэмжийн даатгал	7,541,800.00	6,713,632.60	<b>828,167.40</b>	89.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,033,400.00	5,359,574.61	<b>673,825.39</b>	88.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,508,300.00	1,283,862.14	<b>224,437.86</b>	85.1
210205	Эрүүл мэндийн даатгал	15,083,600.00	12,837,612.58	<b>2,245,987.42</b>	85.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>128,489,344.84</b>	<b>128,489,344.84</b>	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,615,544.84	9,615,544.84	-	100.0
210302	Түлш, халаалт	115,102,300.00	115,102,300.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,771,500.00	3,771,500.00	-	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,711,900.00</b>	<b>31,475,485.00</b>	<b>2,236,415.00</b>	93.4
210502	Хоол, хүнс	33,711,900.00	31,475,485.00	<b>2,236,415.00</b>	93.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,892,600.00</b>	<b>7,892,600.00</b>	-	100.0
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,892,600.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,922,100.00</b>	<b>7,921,180.00</b>	<b>920.00</b>	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,324,400.00	2,324,400.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,597,700.00	5,596,780.00	<b>920.00</b>	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,503,988.14</b>	<b>56,518,270.00</b>	<b>3,985,718.14</b>	93.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,956,788.14	48,121,770.00	3,835,018.14	92.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,547,200.00	8,396,500.00	150,700.00	98.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,540,000.00</b>	<b>31,865,050.00</b>	<b>10,674,950.00</b>	74.9
<b>2132</b>	<b>Бусад урсгал</b>	<b>42,540,000.00</b>	<b>31,865,050.00</b>	<b>10,674,950.00</b>	74.9

	<b>шилжүүлэг</b>				
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,540,000.00	31,865,050.00	10,674,950.00	74.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,129,512,232.98</b>	<b>1,057,007,444.84</b>	<b>72,504,788.14</b>	93.6
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>918,051,100.00</b>	<b>918,051,100.00</b>	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	918,051,100.00	918,051,100.00	-	100.0
	Орон нутгийн төсөв	136,381,944.84	136,381,944.84		
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>75,079,188.14</b>	<b>2,574,400.00</b>	<b>72,504,788.14</b>	3.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,574,400.00	2,324,400.00	<b>250,000.00</b>	90.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,167,000.00	1,167,018.00	<b>(18.00)</b>	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	71,337,788.14	0.00	<b>71,337,788.14</b>	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	71,337,788.14	<b>(71,337,788.14)</b>	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	109,310,624.23	<b>(109,310,624.23)</b>	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж хамтдаа хөгжиж амжилтаа ахиулцгаая” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд нэг бүрийг завсардалтгүй тэгш хамруулан сургаж төлөвшүүлэн авьяасыг нээн хөгжүүлэх
- Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн үед бэлэн байдлыг ханган бэлэн байдлыг ханган цахим даалгаврын сан бүрдүүлж сургалтын арга хэлбэрийг сонгон заах арга зүйгээ хөгжүүлэх
- Эрүүл аюулгүй ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх

- Сурлагын хоцрогдлыг арилгах нөхөх сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулах хүүхэд нэг бүрийн ахиц амжилт
- Эрүүл мэндийн байдал /эрүүл чийрэг байдал, эрүүл харилцаа, эрүүл аюулгүй орчин/

### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧИН

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 57,070.8 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	71,337.80	109,310.60	37,972.80
Авлага	2,719.80	-	(2,719.80)
Бараа материал	7,541.90	26,775.40	19,233.50
Үндсэн хөрөнгө	1,351,252.50	1,353,836.80	2,584.30
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,432,852.00</b>	<b>1,489,922.80</b>	<b>57,070.80</b>
Өр төлбөр		34,507.80	34,507.80
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,432,852.00	1,455,415.00	22,563.00
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,432,852.00</b>	<b>1,489,922.80</b>	<b>57,070.80</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 109,310.6 мянган төгрөг болж 37,972.8 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9<sup>1</sup>-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Авлага дансны үлдэгдэл 2,719.8 мянган төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлүүлэгчдээс авах хүнсний материалын авлагыг барагдуулсан,
- Бараа материал дансны үлдэгдэл 26,775.4 мянган төгрөг болж 19,233.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 95,060.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, аймгийн БШУГ-аас 14,039.5 мянган төгрөгийн номыг үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 89,866.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,353,836.8 мянган төгрөг болж 2,584.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 23,764.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 40,518.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13,674.4 мянган төгрөгийн ном, технологийн кабинетийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, нийт 75,372.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 34,507.8 мянган төгрөгөөр өссөн нь халаалтын зардлын өр төлбөр үүсгэсэнээс тус тус шалтгаалсан байна.

### 3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,586,293.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 136,750.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **1,723,044.5** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-н зардлыг 583,047.7 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 10,853.2 мянган төгрөгөөр бууруулж, тогтмол зардлыг 368.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт **1,129,512.2** мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

---

<sup>1</sup> Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр **1,129,512.2** мянган төгрөгийн төсөв баталснаас 989,388.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 136,382.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,167.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 250.0 мянган төгрөгийг тендерийн хураамжийн орлогоос, түрээсийн номын орлого 2,324.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,020,201.6** мянган төгрөг буюу 90.3 хувьтай тайлагнагдсан нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 86,233.9 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 10,675.0 мянган төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээний зардлыг 8,214.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,187.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

		<i>/мянган төгрөгөөр/</i>					
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
1	<b>71802 Ерөнхий боловсрол</b>	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	2,318.40	2,174.00	(144.40)	93.8
		2	80312- Сургалт семинар	2,197.60	1,944.80	(252.80)	88.5
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,265.70	2,196.00	(69.70)	96.9
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	42,540.00	31,865.00	(10,675.00)	74.9
		5	81806- Дотуур байрны үйлчилгээ	58,160.05	49,945.50	(8,214.55)	85.9
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	26,374.60	26,312.60	(62.00)	99.8
		7	81823- Боловсролын багшийн сургалт	6,793.80	6,608.00	(185.80)	97.3
		8	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	7,244.90	6,702.60	(542.30)	92.5
		9	81834- Боловсролын стандарт сургалт	660,800.40	578,415.20	(82,385.20)	87.5

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмж өгөх.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тооцооллын алдаанаас шалтгаалан 185.2 мянган төгрөгийн цалин илүү олгосон зөрчилд акт тогтоож, 6,440.8 мянган төгрөгийн төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага үүсгэсэн, төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй худалдан авалт хийсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	185.2	1	185.2	100
Албан шаардлага	1	6,440.8	1	6,440.8	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>6,626.0</b>	<b>2</b>	<b>6,626.0</b>	<b>100</b>

#### 4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын

	10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	178,164.00	174,315.30	(3,848.70)	97.8
	11	81848-Сурах бичгийн түрээс	2,574.40	2,324.40	(250.00)	90.3
	12	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	136,381.90	136,381.90	-	100.0
	13	83602-Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан	3,696.45	1,016.30	(2,680.15)	27.5
	<b>Нийт</b>		<b>1,129,512.20</b>	<b>1,020,201.60</b>	<b>(109,310.60)</b>	<b>90.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Дотуур байрны хоол	58,160.0		НТШ
2	Үдийн цай	42,540.0		НТШ
	<b>Нийт дүн</b>	<b>100,700.0</b>		

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч аж ахуй нэгж байгууллагууд

оролцоогүй тул тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн */цаашид Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль гэх/* 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 887,574.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,875.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хушаат сумын ерөнхий боловсролын сургууль нь мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож, 12 мэдээллийг огт мэдээлээгүй байна.Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 12 удаа огт мэдээлээгүй,
- Бусад мэдээллийг 8 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.9 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :**

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Сэлэнгэ шижир тулга” ХХК, “Хөшөө чулуу” ХХК-тай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Өмнөх онд нягтлан бодогч Ц.Отгонсүрэнгийн ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал уг албан бичгийн дагуу нэг сарын үндсэн цалин буюу 1,114.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **884.0** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа.Үүнд:

- Тендерийн хураамжийн 250.0 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын “Санхүүгийн үр дүнгийн тайлан” 5.1 дэх “Санхүүгийн үр дүнгийн тайлан нь байгууллагын тайлангийн хугацааны үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг харуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Хандиваар ирсэн 268.0 мянган төгрөгийн ном, 366.0 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүнийг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.”, 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **1,878.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 300.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,578.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

1. Жижүүр Б.Шинэбаярт цагийн бүртгэлээр баталгаажуулаагүй байхад 300.0 мянган төгрөгийн илүү цагийн хөлс тооцож олгосон нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангаарх үдийн цай, дотуур байрны хоолны материалын орлогын дүн няравын тайлангаас 625.8 мянган төгрөгөөр, зарлагын дүн 952.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “ ... ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн.

1.2 Өгсөн зөвлөмж: Хүнсний материалын худалдан авалт, зарцуулалтыг тухай бүр бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>2</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Орлого тусгаагүй.	1	250.0	1	250.0			1	250.0				
Хандивын ном, сургалтын хэрэглэгдэх үүнийг тусгаагүй.	2	634.0	2	634.0			2	634.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>884.0</b>	<b>3</b>	<b>884.0</b>			<b>3</b>	<b>884.0</b>				

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон.	1	300.0	1	300.0								
Хүнсний материалыг зөрүүтэй тайлагнасан	1	1,578.2					1	1,578.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,878.2</b>	<b>1</b>	<b>300.0</b>			<b>1</b>	<b>1,578.2</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны 8 мэдээллийг хугацаа хоцроож, 12 мэдээллийг огт мэдээлээгүй.	1	-							1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>							<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Худалдан авах ажиллагаатай холбоотой.	1	-							1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>							<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>-</b>							<b>2</b>	<b>-</b>